



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/80


Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Нийслэлийн 2019 оны төсөв батлах тухай” 2018 оны 02/17 дугаар тогтоол, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 9/10 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт гадна зар сурталчилгаа байрлуулахад дагаж мөрдөх журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1.4, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны А/72 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны 01 дүгээр зөвлөмжийн дагуу “Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, хуучнаар Хүнсний 20 дугаар дэлгүүрийн урд байрлах явган хүний нүхэн гарцын түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй их засварын ажил”-ыг гэрээний хүрээнд зохион байгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж, явц үр дүнг тайлагнан ажиллахыг Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /Г.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.

2. Дээрх ажилд шаардагдах 70,000,000 /Далан сая/ төгрөгийг Авто зам, Замын байгууламж, Гүүрэн байгууламж, нүхэн гарцын байгууламж ашиглалт, үйлчилгээний зардлаас санхүүжүүлэхийг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР

